

## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН 28 ДУГААР ХУРАЛДААН

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 28 дугаар хуралдааныг 12 цаг 00 минутад Нутгийн удирдлагын ордны II давхрын хурлын танхимд хийж, Зөвлөлийн гишүүдийн 80.0 хувийн ирцтэй хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	“Хэвлэл мэдээллийн тогтвортой хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөр	ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Хэвлэл мэдээллийн тогтвортой хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийг хэлэлцэх явцад аймгийн Засаг даргын Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусган сайжруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Ганболд, Орон нутгийн сэтгүүлчдийн холбооны удирдах зөвлөлийн дарга Г.Төрмөнх нарт үүрэг болгов.
2	Нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай	ШИЙДВЭРЛЭСЭН нь: Аймгийн хэмжээнд 2022 онд зохион байгуулах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, 2019 оны 204 дүгээр тогтоолоор баталсан "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийн жагсаалт", "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам"-нд нийцүүлэн дахин нягтлан шалгаж, төлөвлөгөөг хэлэлцэх явцад аймгийн Засаг даргын Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусган, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Ганболд, мэргэжилтэн Б.Энхбаатар нарт үүрэг болгов.
3	Соёл, урлагийн газрын байрны асуудлыг шийдвэрлэх тухай	ШИЙДВЭРЛЭСЭН нь: Соёл, урлагийн газарт Жаргалант сумын Цаст-Алтай цогцолбор сургуулийн байрыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд үнэ, төлбөргүй ашиглах гэрээ байгуулахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Н.Ганзоригт даалгав.
4	2022 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн бэлтгэл хангах тухай	ШИЙДВЭРЛЭСЭН нь: Сум, байгууллагуудын ХАСХОМ хариуцсан эрх бүхий албан тушаалтнууд сургалт зохион байгуулж, удирдлага арга зүйгээр ханган, аймгийн Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн 2022 оны тайланг хугацаанд нь гаргаж тайлагнахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Н.Ганзориг, ахлах мэргэжилтэн Ч.Эрдэнэбат нарт үүрэг болгов.
5	Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай	ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын эрхлэх

		<p>асуудлын хүрээний агентлагуудын бүтцийн дагуу судалгаа, шинжилгээ хийж, холбогдох саналыг танилцуулах;</p> <p>2. Сумдын Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоо баталсан хууль тогтоомжийг судалж, жишиг бүтэц боловсруулан дараагийн аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболд, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Ганболд, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдал, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Н.Ганзориг нарт тус тус даалгав.</p>
--	--	---

## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР